

Захидал гэдэг нь дугтуйн дээр хүлээн авагч болон илгээгчийн тухай бичиж илгээсэн зурвас юм.

Танд зориулсан захидал:

Хэрэв танд баталгаат захидал ирээд, та гэртэй байхгүй хүлээж аваагүй бол шуудан дээр хадгалагдана. Шууданд хадгалсан тухай "vůzva k vyzvednutí" гэсэн цаасаар танд мэдэгдэнэ – үүнийг таны шуудангийн хайрцагт үлдээнэ. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд мэдэгдлээ хүлээн авахгүй байх тохиолдол гардаг – жишээ нь: хэн нэгэн мэдэгдлийг тань авах эсвэл шуудангийн хайрцагт мэдэгдэл хийхээ мартаж. 10 хоногийн дараа та ямар нэгэн шалтгаанаар илгээмжийг хүлээн аваагүй байсан ч хүргэлтийг хүргэсэн гэж үзнэ (fikce doručení гэж нэрлэдэг). Захидал дээр асуудлыг шийдвэрлэх хугацааг заасан байх магадлалтай бол та мэдэхгүйгээр хугацаан явагдаж байна гэсэн үг юм. Хэрэв танд илгээмж хүргэлтэд асуудал гарвал Чех шуудангаас гаргадаг, шуудангийн хайрцаг (box) эсвэл мэдээллийн хайрцаг байгуулж болно. Хэрэв та чухал захидал хүлээж байгаа бол Чех шуудангаас танд захидал ирсэн эсэхийг асууж болно.

Иймд ОРШИН СУУГАА ГАЗАРТАА
ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ БОЛОН ХОНХОО
ТЭМДЭГЛЭГДСЭН байх шаардлагатай.

Танаас ирсэн захидал:

Хэрэв та хэн нэгэнд захидал илгээж байгаа бол ердийнхөөр (захиа илгээсэн гэдэг баталгаа шуудангаас авахгүй) эсвэл баталгаат шуудангаар илгээх эсэхээ шийдэх нь чухал юм. Хэрэв та захиргааны газрууд болон байгууллагатай харилцаж байгаа бол захиаг баталгаат шуудангаар илгээхийг бид зөвлөж байна. Үүнийг илгээхдээ та хүргэх хуудас бөглөх ёстой бөгөөд үүнийг Чех шуудангаар баталгаажуулж, танд буцааж өгөх болно. Энэ нь таныг хамгаалах зорилготой бөгөөд та жинхэнээсээ захиа илгээсэн мөн хэзээ илгээсэн гэдэг нь байна. Тийм учраас үүнийг хадгалах нь чухал юм.

Танд илгээсэн захидал нь янз бүрийн хэлбэрээр байж болох ба өнгөөр тэмдэглэсэн байх боломжтой.

Ердийн захидал: энгийн харилцаанд хэрэглэгддэг. Захиаг шуудангийн хайрцагт хийнэ.

Баталгаат захидал:

Өөрийн биеэр - илгээмжийг зөвхөн хүлээн авагч, эрх бүхий хүн, хүлээн авагчийн төлөөлөгч, хүлээн авагчийн хууль ёсны асран хамгаалагч эсвэл хүлээн авагчийн хууль ёсны

асрах хамгаалагчийн төлөөлөгчдөд хүлээлгэн өгнө.

Зөвхөн хүлээн авагчийн гарт хүргэх - илгээмжийг зөвхөн хүлээн авагч өөрөө авна.

Өнгөөр тэмдэглэгдсэн дугтуйнууд – дугтуйн зүүн талд өнгөтэй судал байна:

- цэнхэр өнгө - дугтуйг төлөөлөгч хүлээн авах боломжтой (ихэвчлэн мэдээллийн шинж чанартай жишээ нь: сургууль, санхүүгийн эсвэл бизнес эрхэлж болох лицензийн газраас ирсэн мэдээллүүд байдаг). Хэрэв энэ нь дугтуйн дээр "өөрийн гарт" гэж бичсэн бол энэ нь улаан судалтай захидлын үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зөвхөн хүлээн авагч өөрөө хүлээн авах боломжтой.

- улаан өнгө - дугтуйг зөвхөн хүлээн авагч хүлээн авах боломжтой (энэ нь маш чухал захидлууд байна, жишээ нь: цагдаагаас дуудах хуудас, Нийгмийн хамгааллын газраас сэрэмжлүүлэг ...).

- нил ягаан өнгө - Чехийн шуудангаас илгээсэн захидал бөгөөд хүлээн авагчид зориулсан DINO үйлчилгээ юм – иргэдийн өр цуглуулах.

- ногоон өнгө - дугтуйг зөвхөн хүлээн авагч хүлээн авах боломжтой (жишээ нь: шүүх хуралд дуудах хуудас, шүүх тогтоолыг албадан гүйцэтгэх захирамж ...)

- шар өнгө - PIN илгээмж гэж нэрлэгддэг, энэ нь ISDS-руу хандалтын мэдээллийг илгээхэд ашигладаг (Мэдээллийн системийн өгөгдлийг хайрцаг – аж ахуй нэгжийн улсын бүртгэгд бүртгэгдсэн хуулийн этгээдэд ашигладаг).

Зарим дугтуйнуудад гардуулалтын лавлагаа гэж нэрлэгддэг бичиг байдаг – захидал авах үедээ өөрийн гарын үсэг зурснаар захидлыг хүлээн авсны баталгаажуулах болно. Илгээгч нь хүргэлтийн баталгааг бичгээр хүлээн авна.

!!! АНХААР !!!

- Хэрэв танд ямар ч өнгөний тэмдэглэгээгүй баталгаат захидал ирсэн бол энэ нь ямар ч ач холбогдолгүй гэсэн үг биш юм. Иймээс та үүнийг очиж авах хэрэгтэй !!
- ЗӨВ ОРШИН СУУХ ХАЯГАА ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД МЭДЭГДЭХ НЬ ЧУХАЛ МӨН ОРШИН СУУХ ГАЗРЫН ШУУДАНГИЙН ХАЙРЦАГ БОЛОН ХОНХ ДЭЭР НЭРЭЭ БИЧИХ.